

## ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛИЙН 27.1.8, 27.4 ДАХЬ ЗААЛТУУДЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

2014.06.03

Улаанбаатар хот

Иргэн Г.Цэдэнбалжир, Ц.Сарантуяа, Д.Дашдаваа, М.Хуандаг, Н.Гансүх нараас төрийн алба (Үндэсний аудитын газар, Баянгол дүүргийн 13-р сургууль, Дорнод аймгийн засаг даргын тамгын газар, Баян-Өлгий аймгийн татварын хэлтэс, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар)-нд олон жил үр бүтээлтэй ажиллаж ирсэн ч өвчний улмаас өртөг өндөртэй эм тариа хэрэглэх, гадаад улсад эмчлүүлэх шаардлагатай болсон тул эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлэхийг өөрийн ажилладаг байгууллагаас хүссэн боловч шийдвэрлээгүй тул Улсын Их Хурлын гишүүн Р.Бурмаа, Ц.Даваасүрэн, М.Зоригт, Н.Номтойбаяр нарт хандан тусламж хүссэн өргөдөл гаргасныг тус Байнгын хороогоор шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн байна.

Байнгын хорооны 2013 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 03 тоот тогтоолоор баталсан “Өргөдлийн байнгын хорооны гишүүдийн ажиллах чиг үүргийн хуваарь, өргөдөл шийдвэрлэх журам”-ын дагуу эдгээр өргөдлийг шийдвэрлүүлэхээр Улсын Их Хурлын гишүүн М.Зоригт, Д.Сарангэрэл нарт хуваарилагдсаны дагуу судлан дараах санал, дүгнэлтийг боловсруулан Байнгын хороонд танилцуулж байна.

### **Өргөдлийн дагуу хуулийн хэрэгжилтийг судалсан талаар:**

Засгийн газрын 2011 оны 226 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2013 оны 313 дугаар тушаалаар баталсан “Зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлэх иргэнд сан-хүүжилт олгох журам”-д заасны дагуу Эрүүл мэндийн сайдын тушаалаар иргэдийн эмчилгээний зардлын 5 хувийг тусламж болгон олгож байна.

Харин төрийн албан хаагчийн хувьд Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин зургадугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хуулиар тогтооно”, Төрийн албаны тухай хуулийн 27.1.8 дахь заалтад төрийн албан хаагч нь **“Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан тухайн жилийн эмчилгээний төлбөрийн хэмжээнээс давсан хэсэг болон магадлан итгэмжлэл бүхий эмнэлгийн байгууллагын шийдвэрээр гадаад оронд эмчлүүлэх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд зардлынх нь 60-аас доошгүй хувийг төр хариуцах”, 27.4-т “27.1.5, 27.1.8, 27.2.5-д заасан нэмэлт баталгаатай холбогдох журмыг Засгийн газар тогтооно.”** гэж тус тус заасны дагуу нийгмийн баталгаагаар хангагдах эрхтэй байна.

Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалтад Төрийн албаны зөвлөл нь “төрийн байгууллагаас төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр болон ажиллах нөхцөл, **нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг арга зүйн удирдлагаар хангах**” бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заажээ.

Мөн Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт Эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээнд дотрын өвчний, мэдрэлийн тогтолцооны өвчний, нүд, чих, арьс ба халимын, яс, булчин, холбох нэхдэсийн өвчний, яаралтай бус гэмтэл, мэс заслын өвчний тусламж үйлчилгээ хамаарах бөгөөд мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэгт “Энэ хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасан эрүүл мэндийн

даатгалын тусламж, үйлчилгээний жагсаалт болон тэдгээрийг санхүүжүүлэх төлбөрийн аргыг хууль тогтоомжид нийцүүлэн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.”, 12 дугаар зүйлийн 12.11 дэх хэсэгт “Даатгуулагчид эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний зардлын даатгалын сангаас санхүүжүүлэх дээд хязгаарыг даатгалын зөвлөл жил бүр тогтооно” гэж тус тус заасан байна.

Иргэдийн өргөдөлд дурдсанаас үзэхэд Төрийн албаны тухай хуулийн 27.1.8-д заасан тусламж үйлчилгээг авах талаар өөрийн ажиллаж буй байгууллагад хандахад санхүүжилтийн эх үүсвэр байхгүй, байгууллагын дотоод журамд зааснаар шийдвэрлэнэ гэх зэрэг хариуг өгч асуудлыг хуульд заасны дагуу шийдвэрлээгүй байна.

### **Санал, дүгнэлт**

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4-дэх хэсэгт заасан журмыг Засгийн газар баталж мөрдөөгүйгээс мөн хуулийн 27.1.8 дахь заалт хэрэгжихгүй байна. Үүний улмаас төрийн албан хаагчид хуульд заасан нийгмийн баталгаагаар хангагдаж чадахгүй хохирч байна.

Төрийн албан хаагчийн хуулиар тогтоосон нийгмийн баталгааг хангах, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан тухайн жилийн эмчилгээний төлбөрийн хэмжээнээс давсан хэсэг болон магадлан итгэмжлэл бүхий эмнэлгийн байгууллагын шийдвэрээр гадаад оронд эмчлүүлэх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд зардлынх нь 60-аас доошгүй хувийг төр хариуцаж, төрийн албан хаагчид хэрхэн олгох талаар Төрийн албаны зөвлөлийн саналыг харгалзан Сангийн яам, Эрүүл мэндийн яамны хамтарсан журам батлан гаргах, зардлыг төсөвт тусган хэрэгжилтийг хангаж ажиллах, хуулийн заалт хэрэгжээгүйгээс хохирч буй төрийн албан хаагчдын гомдлыг барагдуулах чиглэлийг Засгийн газарт өгөх нь зүйтэй гэж үзэв.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

М.ЗОРИГТ

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Д.САРАНГЭРЭЛ

УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

**Хуулийн хэрэгжилтийг хангах асуудлаар  
чиглэл өгөх тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.4 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэгт заасныг үндэслэн Өргөдлийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Төрийн албан хаагчийн эмчилгээний зардлын тодорхой хувийг төрөөс хариуцах талаарх Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.8 дахь заалтын хэрэгжилтийг хангах, хуульд заасан журмыг баталж мөрдөх, зардлыг төсөвт тусгаж байх, төрийн албан хаагчдын эмчилгээний зардлыг хуульд заасны дагуу олгох талаар зохих арга хэмжээ авч ажиллан 2014 онд багтаан тус Байнгын хороонд танилцуулахыг Засгийн газар /Н.Алтанхуяг/-т чиглэл болгосугай.

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Р.БУРМАА

## ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЛАВЛАГАА

<b>Монгол Улсын Үндсэн хууль</b>	<b>Дөчин зургадугаар зүйл.</b> 1. Монгол Улсын яам, төрийн бусад албан газрыг хуулийн дагуу байгуулна. 2. Монгол Улсын төрийн жинхэнэ албан хаагч Монгол Улсын иргэн байх бөгөөд Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж ард түмнийхээ тусын тулд, иргэний ёсоор төрийн ашиг сонирхолд захирагдан ажиллана. 3. Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хуулиар тогтооно.
<b>Төрийн албаны тухай хууль</b>	<b>27 дугаар зүйл. Төрийн албан хаагчийн баталгаа</b> 27.1. Төрийн албан хаагч дараахь баталгаагаар хангагдана: 27.1.8. Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан тухайн жилийн эмчилгээний төлбөрийн хэмжээнээс давсан хэсэг болон магадлан итгэмжлэл бүхий эмнэлгийн байгууллагын шийдвэрээр гадаад оронд эмчлүүлэх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд зардлынх нь 60-аас доошгүй хувийг төр хариуцах; <b>34 дүгээр зүйл. Төрийн албаны төв байгууллага</b> 34.1. Төрийн албаны төв байгууллага нь Төрийн албаны зөвлөл /цаашид "Зөвлөл" гэх/ мөн. 34.2. Зөвлөл нь хараат бус бие даасан байгууллага бөгөөд үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд тайлагнана. <b>35 дугаар зүйл. Зөвлөлийн бүрэн эрх</b> 35.1. Зөвлөл нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 35.1.13. төрийн байгууллагаас төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр болон ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг арга зүйн удирдлагаар хангах; <b>38 дугаар зүйл. Төрийн албаны санхүүжилт</b> 38.1. Төрийн албаны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ. 38.2. Төрийн албаны зардлыг бууруулах арга хэмжээ авч төсвийн санхүүжилтийг хорогдуулах нь төрөөс олгож байгаа төрийн албан хаагчдад олгох төлбөрийг түр буюу бүрмөсөн зогсоох, тэдний цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг бууруулах үндэслэл болохгүй.

<p><b>Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль</b></p>	<p><b>7 дугаар зүйл. Даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ</b></p> <p>7.1. Эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээнд дараахь тусламж үйлчилгээ хамаарна:</p> <p>7.1.1. дотрын өвчний;</p> <p>7.1.2. мэдрэлийн тогтолцооны өвчний;</p> <p>7.1.3. нүд, чих, арьс ба халимын, яс, булчин, холбох нэхдэсийн өвчний;</p> <p>7.1.4. яаралтай бус гэмтэл, мэс заслын өвчний.</p> <p>7.4. Энэ хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасан эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний жагсаалт болон тэдгээрийг санхүүжүүлэх төлбөрийн аргыг хууль тогтоомжид нийцүүлэн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.</p> <p><b>12 дугаар зүйл. Даатгуулагчийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөр</b></p> <p>12.1. Даатгуулагчид үзүүлэх тусламж, үйлчилгээний хувьсах зардлын даатгалын сангаас олгох хэмжээг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн эрүүл мэндийн, санхүү, эдийн засгийн, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран тогтооно.</p> <p>12.11. Даатгуулагчид эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний зардлын даатгалын сангаас санхүүжүүлэх дээд хязгаарыг даатгалын зөвлөл жил бүр тогтооно.</p>
<p><b>Засгийн газрын 2011 оны 226 дугаар тогтоол “Зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлэх иргэнд санхүүжилт олгох журам”</b></p>	<p>1.2. Гадаад оронд зайлшгүй эмчлүүлэх шаардлагатай иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудлаар санал гаргах үүрэг бүхий орон тооны бус мэргэжлийн зөвлөл (цаашид "Зөвлөл" гэх) Эрүүл мэндийн сайдын дэргэд ажиллана.</p> <p>1.3. Зөвлөлийн бүрэлдэхүүн, түүний ажиллах журам болон Монгол Улсад оношлох, эмчлэх боломжгүй өвчин, эмгэгийн жагсаалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p> <p>1.4. Зайлшгүй шаардлагаар гадаад оронд эмчлүүлэх иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг эрүүл мэндийн сайдын төсвийн багцад жил бүр тусгана.</p> <p>2.1. "Монгол Улсад оношлох, эмчлэх боломжгүй өвчин, эмгэгийн жагсаалт"-д орсон өвчин, эмгэгтэй болохыг нь улсын хэмжээний үйлчилгээтэй төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн эмнэлэг хяналтын комиссын</p>

	<p>зөвлөлгөөнөөс тогтоож, дүгнэлт гаргуулсан иргэн санхүүгийн дэмжлэг авах тухай хүсэлтээ эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад тавина.</p> <p>2.3. Санхүүгийн дэмжлэг үзүүлэх талаар гаргасан Зөвлөлийн хурлын шийдвэрийг Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталгаажуулж уг тушаалын хувийг Сангийн яамны Төрийн сангийн газарт хүргүүлнэ.</p> <p>2.4. Эрүүл мэндийн сайдын тушаалын дагуу Сангийн яамны Төрийн сангийн газар эрүүл мэндийн сайдын төсвийн багцаас ажлын 5 өдөрт багтаан эмчлүүлэгчийн нэр дээр мөнгийг шилжүүлнэ.</p> <p>4.1. Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь гадаадад эмчлүүлсэн иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх талаар гаргасан шийдвэр, түүний дагуу зарцуулсан хөрөнгийн хэмжээ болон гадаадад эмчлүүлэгчдийн эмчилгээний дүнг Засгийн газарт жил бүр танилцуулна.</p>
<p><b>Эрүүл мэндийн сайдын 2013 оны 313 тоот тушаал</b></p> <p><b>“Гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчлүүлэх иргэнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудлаар санал гаргах орон тооны бус зөвлөлийн ажиллах журам”</b></p>	<p><b>Нэг. Нийтлэг үндэслэл</b></p> <p>1.3. Зөвлөл нь “Гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчлүүлэх өвчний жагсаалт”-д орсон өвчин, эмгэгтэй болохыг нь Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.10, 15.1.12-т заасан эмнэлгийн эмч нарын комиссын зөвлөгөөнөөс тогтоож, дүгнэлт гаргуулсан иргэнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудлыг зөвлөлдөн нийт гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.</p> <p>1.4. Зөвлөл нь 2 сар тутамд 1 удаа хуралдана. Шаардлагатай үед зөвлөлийн даргын шийдвэрээр хурлыг зарлан хуралдуулж болно. Хурлыг Зөвлөлийн дарга, түүний эзгүйд дэд дарга даргална.</p> <p>1.5. Зөвлөл нь хуралдааны талаар хурлын тэмдэглэл хөтөлж, олонхийн саналаар шийдвэрлэсэн асуудлыг Эрүүл мэндийн сайдад танилцуулж шийдвэр гаргуулна. Тэмдэглэлийг нарийн бичгийн дарга хөтөлж, зөвлөлийн дарга, дэд дарга нар хянаж гарын үсэг зурж баталгаажуулна.</p> <p><b>Гурав. Гадаад улсад эмчлүүлэх зардал</b></p> <p>3.1. Зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлэх иргэнд санхүүгийн дэмжлэгийг тухайн өвчнөөр нэг удаа олгоно.</p> <p>3.2. Эмчилгээнд санхүүгийн дэмжлэг үзүүлэхдээ тухайн иргэнийг эмчилж эрүүлжүүлэхэд зарцуулагдсан зардлын баримт, материалыг үндэслэнэ.</p> <p>3.3. Иргэний гадаад улсад очиж эмчилгээнд зарцуулсан нийт зардлын 5 хувийг үндэсний мөнгөн тэмдэгтээр бодож</p>

	<p>олгох ба тухайн үеийн Монгол банкны ханшаар тооцно. 3.4. Гадаад улсад эмчлүүлсэн иргэний тээвэр байр, хоол, түүнчлэн асран хамгаалагчаар явсан хүнд зардал олгохгүй.</p>
--	---